МЭДЭЭ · 2022 оны 10-р сарын 10

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР Б.ЖАРГАЛСАЙХАН ОЛОН УЛСЫН ПРОКУРОРУУДЫН ХОЛБООНЫ ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦЛОО



Монгол Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайхан тэргүүтэй төлөөлөгчид Гүрж улсын нийслэл Тбилиси хотноо зохион байгуулагдсан Олон Улсын Прокуроруудын Холбооны 27 дугаар чуулга уулзалтад оролцлоо.

Энэ удаагийн чуулга уулзалт “Олон улсын эрүүгийн эрх зүйн өөрчлөлт, цаашдын чиг хандлага” сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж, Америк, Англи, Швейцар, Сингапур, Швед, Нидерланд, Франц, Канад зэрэг дэлхийн 68 улс, олон улсын 9 байгууллага, 33 улсын Ерөнхий прокурор, нийт 308 төлөөлөгч оролцсон байна.





Чуулга уулзалтын хүрээнд “Эрүүгийн эрх зүйн тогтолцоон дахь цахим өөрчлөлтүүд, Кибер гэмт хэргийн зүйлчлэл, хувьсал, Цахим нотлох баримт, Сэтгүүл зүй, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа, Гадаад улсаас цахим нотлох баримт цуглуулахад тулгарч буй бэрхшээл, Виртуал хөрөнгийг мөрдөх, илрүүлэх, царцаах” зэрэг асуудлаар прокурор, мэргэжилтнүүд илтгэл хэлэлцүүлжээ.

Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан чуулга уулзалтын үеэр Бүгд

Найрамдах Австри Улсын ерөнхий прокурор Франз Плохл, Бүгд Найрамдах Сингапур Улсын ерөнхий прокурор Люсиен Вонг Юен Кай, Бүгд Найрамдах Турк Улсын ерөнхий прокурор Бекир Сахин, Бүгд Найрамдах Азербайжан Улсын ерөнхий прокурор Камран Алиев болон бусад төлөөлөгчидтэй ажил хэргийн уулзалт хийж прокурорын байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцож, харилцан дэмжиж ажиллахаар болсон байна.

Тухайлбал, Бүгд Найрамдах Австри Улсын ерөнхий прокурор Франз Плохлтой Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Бүгд Найрамдах Австри Улсын Ерөнхий прокурорын газар хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийг үр дүнтэй хэрэгжүүлэх, улс дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийг хянан шийдвэрлэх сэдвээр сургалт зохион байгуулж, прокуроруудыг мэргэшүүлэх, харилцан туршлага солилцох чиглэлээр тодорхой санал солилцож, хоёр улсын хооронд эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхээр тохиролцлоо.





Бүгд Найрамдах Сингапур Улсын ерөнхий прокурор Люсиен Вонг Юен Кайтай уулзаж, Монгол Улс Бүгд Найрамдах Сингапур улсын хооронд эрх зүйн туслалцааны гэрээ байхгүй, эрх зүйн туслалцааны хүсэлт илгээхэд удааширдаг тул Сингапур Улсын Ерөнхий прокурорын газар нь тус улсын эрүүгийн хэрэг дэх эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах төв байгууллага болохын хувьд эрх зүйн харилцан гэрээгүй ч хоёр улсын эрүүгийн хэрэгт харилцан илгээж буй эрх зүйн туслалцааны хүсэлтүүдийг шуурхай шийдвэрлэхэд анхаарч ажиллахаар болж, манай улсын прокурорын байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, гадаад хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх, ойрын үед манай 2 прокурорыг Сингапур Улсад тус улсын эрх зүйн орчныг судлуулах зэргээр хамтран ажиллахаар тохиролцсон.





Азербайжан Улсын ерөнхий прокурор Камран Алиевтай тус улсын прокурорын газрын Шинжлэх ухаан, боловсролын төвтэй хамтран прокурор солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, хууль, эрх зүйн тогтолцоо, прокурорын хяналтын ажлын чиглэлээр

мэдээлэл, туршлага солилцох боломжтой эсэх талаар ярилцлаа. Тэрбээр дээрх чиглэлүүдээр хамтран ажиллахаа илэрхийлж, Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайханыг таатай үедээ тус улсад айлчлан ирэхийг урилаа.



Чуулга уулзалтын үеэр Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий прокурор Бэкир Сахинтай уулзсан бөгөөд тэрээр манай улсад 2023 онд айлчлан ирэхийг урьсан урилгыг талархан хүлээн авсан байна.

Мөн Олон Улсын Прокуроруудын Холбооны ерөнхийлөгч, ноён Чёл Кюү Хванг, холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Хан Мораал, холбооны гүйцэтгэх захирал Йаннэ Холст Хюбнэр нартай уулзаж, тус холбооны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй прокурор солилцооны хөтөлбөрт жил бүр 3 прокурорыг 3 сарын хугацаагаар авлига, албан тушаал, мөнгө угаах, терроризмын эсрэг гэмт хэргийг мөрдөх чиглэлээр сургахаар шийдвэрлэлээ.

Олон Улсын Прокуроруудын Холбоонд манай улс 1996 онд “Монголын Прокуроруудын Холбоо” төрийн бус байгууллагаар элсэн орж байсан бол Монгол Улсын Прокурорын байгууллагыг энэ онд тус холбоонд “Гишүүн-байгууллага”-аар элсүүлэх талаар Олон Улсын Прокуроруудын Холбооны гаргасан саналыг Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан судлан үзэхээ илэрхийлэв.

Монгол Улсын прокурорын байгууллага Олон Улсын Прокуроруудын Холбоонд элссэнээр тус холбооны бүхий л үйл ажиллагаанд оролцох, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, олон улсын прокуроруудын нэгдсэн сүлжээнд орох, мөн тус холбооны бүх шатны сонгуульд оролцож, санал өгөх боломжтой болох юм.


EXIT


27TH ANNUAL
IAP
INTERNATIONAL ASSOCIATION OF PROSECUTORS







Видео: https://www.youtube.com/watch?v=eswYmbmjtww

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1973